Р.ЭНХБОЛД- ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН
АХЛАХ РЕФЕРЕНТ, ДЭД ХУРАНДАА

## ГОЛАНЫ ӨНДӨРЛӨГИЙН ЭРГЭН ТОЙРОНД

Олонд Сирийн Голан эсвэл Голаны өндөрлөг гэдгээр олонд танигдсан нутаг бол далайн түвшнээс дор нам газар ба дов, толгод ихтэй, зүүн талаар Сири, хойд талаар Ливан, зүүн өмнөд талаар Йордан, баруун талаар Израйль Улстай хиллэдэг газар юм. Сирийн Голан нь 1,860 км/кв талбайтай боловч үүний 1,230 км/кв нутгийг 1967 онд Израйлийн цэргийнхэн эзлэж авчээ. Энэ бол Төв аймгийн Архуст сумын нутаг дэвсгэртэй ойролцоо хэмжээтэй жижиг газар юм.

1947 онд НҮБ-ын шийдвэрээр Палестиныг Араб болон Еврей гэсэн хоёр улс болгож хуваав. Үүнийг арабчууд эрс эсэргүүцэж байсан ба 1948 онд Израйль Улсыг тусгаар тогтнолоо зарлаад хэдхэн хоножж байхад нь арабын 5 улс нийлж Израйль руу довтолжээ. Израйль нь Англи, Франц, Чехээс богино хугацаанд цэргийн тусламж авсны үр дүнд арабын орнуудыг ялсан ба үр дүн нь Йордан голын баруун эрэг, Газын зурвас, Синайн хойгийг эзлэж авсан нь одоо болтол маргаан дагуулсан хэвээр байгаа юм.




Зураг №01. Голаны өндөрлөгийн ерөнхий зураг

1967 оны 6 дугаар сарын 05-ны өглөө Египет болон Сири Улс ойролцоогоор 600 мянган цэрэг, 2 мянган нэгж танк, 2,3 мянган хуягт тээвэрлэгч, 550 нэгж нисэх онгоц бүхий цэргийн хүчээр Израйлийн хоёр талаас гэнэтийн цохилт өгчээ. Тэдний эсрэг Израйль улс нь 310 мянган цэрэг бүхий хүчээр сөрөн байлдсан ба тулаан 6 хоногийн дараа израйлийн ялалтаар өндөрлөв. Үр дүнд нь Сири Улс Голаны өндөрлөг газраас 1,230 км/кв нутгийг алдаж, 100 мянга гаруй Сирийн иргэд дүрвэж, өөр газар шилжин суурьшсан байна.

1973 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Египет болон Сирийн цэрэг Израйль руу довтолсноор Араб-Израйлийн хоёрдугаар дайн эхлэв. Израйлийн 3 мянга гаруй цэрэг, 180 нэгж танк, 60 их буу байрлаж байсан Голаны өндөрлөг руу Сирийн 28 мянган цэрэг, 800 нэгж танк, 600 гаруй их буу бүхий хүчээр дайралт хийлээ. Ширүүн тулалдаан болж америкийн тусламжтайгаар израйльчууд ялалт байгуулж, өндөрлөг дээрх байрлалаа хадгалж үлдсэн байна. Гэвч Израйль болон Сирийн цэргийн хооронд зэвсэгт мөргөлдөөн тасралтгүй явагдаж байсан тул 1974 онд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс НҮБ-ын Гал зогсоох хэлэлцээрийг хянах ажиглах хүчин байгуулах шийдвэр гаргасан байна.

1967 оны дайны үеэр Голаны өндөрлөгт амьдарч байсан арабууд болон мөргөлдөөн болж буй районоос 100 мянга гаруй иргэд нутгаа орхин зугтсан ба тэдний оронд израйлийн иргэд олноор орж ирж суурьших болжээ. Өнөөдөр энд израйлийн 34 тосгонд 23 мянган иргэд амьдарч байгаа бол нутгийн уугуул сирийн дрюзе омгийн 25 мянган хүн амьдарсан хэвээр байна. Эдгээр иргэдийн ихэнх нь Сирийн иргэншлээ хадгалж үлдсэн хэвээр боловч Израйлийн иргэн болох сонголт нь нээлттэй байгаа юм.

**Голаны өндөрлөгийг буцааж авах талаар хийсэн Сирийн талын алхам, яриа, хэлэлцээ**

Сири Улс 1967 онд явуулсан дайны үр дүнд Голаны өндөрлөгийг Израйльчуудад алдсан, 1973 онд өндөрлөгийг цэргийн хүчээр буцааж авах зорилгоор хоёр дахь удаа дайн хийсэн боловч дахин ялагджээ. Гэвч Сирийн тал нутаг дэвсгэрээ буцааж авах байнга яриа, хэлэлцээг тасралтгүй явуулж иржээ. Гэтэл 1981 оны 12 дугаар сарын 14-нд Голаны өндөрлөгт Израйлийн засаг захиргаа, хууль үйлчлэх тухай хууль батлан гаргасан нь өндөрлөгийг “өөртөө нэгтгэсэн”-тэй агаар нэгэн үйлдэл байлаа. Гэвч уг үйлдлийг НҮБ-ын Аюулгүйн зөвлөл буруушааж уг нутгийг “Израйлийн эзэлсэн Сирийн газар" хэвээрээ гэдгийг баталсан 497 дугаар тогтоол баталжээ.

1991 онд Испанид зохион байгуулагдсан “Мадридын бага хурал”-ын дараа Израйль болон Сирийн өндөр хэмжээний төлөөлөгчид хоёр улсын маргаантай асуудлаар уулзалт хийлээ. 1990-ээд оны үед Израйлийн тал Сирийн Ерөнхийлөгч Хафез Ал-Ассадтай хэд хэдэн удаа яриа, тохироо хийхээр уулзаж байлаа. Мөн 1999 онд Израйлийн Ерөнхий сайд Эхуд Барак, Сирийн Ерөнхий сайд Фароук Ал-Шараа хоёр Голаны өндөрлөгийн талаар уузлалт хийж байжээ.

2000 онд АНУ-ын дэмжлэгтэйгээр хоёр маргалдагч талууд уулзсан боловч уулзалт амжилтгүй болсон. 2008 онд Турк Улс зуучлагчийн үүрэг гүйцэтгэж хоёр улсын төлөөлөгчдийг уулзуулсан боловч Газын зурваст явагдсан цэргийн ажиллагааны улмаас уулзалт тасалдаж байв.




Зураг №02. 1982 онд Сири-Израйлийн гал зогсоох хэлэлцээрийн дагуу байрлуулсан хоёр талын зэвсэг, техникийн тоо, хэмжээ

Израйлийн тал 2009 оноос Голаны өндөрлөгийн талаар баримтлах улс төрийн бодлогоо чангаруулсан ба 2009 онд Ерөнхий сайд Б.Нетаньяху Голаны өндөрлөгт Засгийн газраа хуралдуулж, хурлын дараа гадаадын улс орнууд, олон улсын байгууллагуудад хандаж "Голаны өндөрлөг бол Израйлийн нутаг дэвсгэр гэдгийг хүлээн зөвшөөрөхийг уриалж байна” гэсэн мэдэгдэл хийж байв.

2011 онд Сирийн нутаг дэвсгэрт “Исламын Улс” террорист бүлэглэл үүсэж, зэвсэгт мөргөлдөөн эхэлсэн ба Ерөнхийлөгч Башир Ал-Ассадын тэргүүлсэн Засгийн газар нь нутаг дэвсгэрээ бүрэн хянах чадваргүй болсон боловч ОХУ-ын Агаар-сансарын цэргийн хүчний тусламжтайгаар цэргийн ажиллагааг амжилттай явуулж, одоогийн байдлаар газар нутгийнхээ ихэнх хэсгийн хяналтад аваад байна. Гэвч Израйль болон Сирийн хилийн дагуу их бууны харилцан буудлага байнга явагдсаар өнөөдрийг хүрсэн юм.

**Израйль Голаны өндөрлөгийг эзлэж авахын ач холбогдол**

Израйлийн тал 1948-1967онуудад Голаны өндөрлөгт байрлаж байсан Сирийн цэргийн их бууны“овоохараа”-нд байнга өртөж байлаа.Тийм учраас уг өндөрлөгийг эзлэн авах нь стратегийн чухал ач холбогдолтой болж хувирчээ. Уг өндөрлөг дээрээс эргэн тойрны газар нутаг тод, ил харагдахаас гадна Сирийн нийслэл Дамаск хот нь хойд зүгт ердөө 60 км-ийн зайд байрлаж байгаа юм. Израйлийн тал Голаны өндөрлөгийг эзлэн авсан явдал нь дараах ач холбогдолтой юм. Үүнд:

1. Израйль Улс нь хил залгаж буй эргэн тойрны араб орнуудын байнгын аюул, заналхийлэл дунд оршдог. Хамгийн аюултай хөршийн нэг бол Сири Улс учраас тус улсын зүгээс үзүүлж болох цэргийн гэнэтийн цохилтод өртөхгүйн тулд уг өндөрлөгийг өөрийн хяналтад байлгах нь Израйлийн үндэсний аюулгүй байдлын амин чухал асуудал болж хувирчээ. Сирийн цаана Израйлийг газрын хөрснөөс арчих хүсэлтэй Иран Улс байрлаж байгаа ба уг улс нь Израйлийн эсрэг чиглэсэн аливаа улс орон, байгууллагын /тухайлбал Леваны Хезболлах гэх мэтчлэн/ үйл ажиллагаанд зэвсэг, санхүү, мэдээлэл, хүн хүч зэрэг төрөл бүрийн дэмжлэг үзүүлдэг юм. Мөн энэхүү газар нь зөвхөн ажиглалт үйлдэхэд дөхөмтэй өндөрлөг газар байгаад зогсохгүй байр зүйн хувьд Сирийн нутгаас тусгаарласан байгалийн тогтоцтой юм.
2. Израйль Улс байгуулагдсан цагаас хойш өөрийн газар нутгийг байнга тэлж ирсэн ба өнөөдрийн байдлаар 20,7 мянган км/кв нутагтай байгаа нь манай Өмнөговь аймгийн Ноён сумын нутагтай ойролцоо хэмжээтэй юм. Израйлийн өдөр бүр өсөн нэмэгдэж буй 8,2 сая хүн амыг суурьшуулах, хөдөө аж ахуй, газар тариалан, уул уурхайн салбарыг хөгжүүлэхэд газрын хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна.
3. “Йорданы гол” нь Израйлийн усны хэрэгцээний гуравны хоёр хувийг хангадаг усны эх булаг тул стратегийн чухал ач холбогдолтой юм. Гэвч 1965 онд Сири Улс нь Йордан болон Ливантай хуйвалдаж “Йорданы гол”-ын голдирлыг өөрчлөх оролдлого хийсэн нь Израйлийн тал Голаны өндөрлөгийг эзлэж авах шалтгааны нэг болсон юм’.
4. Өнөөдөр Израйль нь Палестинтай 5,655 км/кв газар нутагтай Баруун эрэг/West bank/, 365 км/кв газартай Газын зурвас/Gaza stripZ-ын асуудлаар маргаантай байгаа ба эдгээр нутагт израйлийн иргэдийн суурьшуулах ажлыг тасралтгүй явуулж байгаа юм. Хэрвээ Голаны өндөрлөгийг АНУ-ын тусламжтайгаар Израйлийн албан ёсны газар нутаг хэмээн хүлээн зөвшөөрүүлж чадвал дээрх хоёр газар нутгийг бүр мөсөн мэдэлдээ авахад чухал түлхэц болж өгнө.

1. Reza Behnam “Water and Peace in Middle East” Apr 1,2018

**НҮБ-аас Голаны өндөрлөгт явуулж буй энхийн ажиллагаа**

1973 оны 10 дугаар сард эхэлсэн Араб-Израйлийн хоёрдугаар дайны дараа Израйль болон Сирийн цэргийн хооронд жижиг масштабын зэвсэгт мөргөлдөөн тасралтгүй явагдаж байсан тул 1974 онд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс 350 дугаар тогтоол гарган "НҮБ-ын Гал зогсоох хэлэлцээрийг ажиглах хүчин/United Nations Disengagement Observer Force - UNDOF"-г байгуулах шийдвэр гаргажээ[2]. НҮБ-ын Нарийн бичгийн дарга уг тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 1974 оны 6 дугаар сарын 03-ны өдөр "UNDOF''-ийн хүчний командлагчийг томилон Дамаск хот руу илгээв. Хүчний командлагч нь Тал зогсоох Израйль-Сирийн хамтарсан комисс"-ийн гаргасан шийдвэрийн[3] хүрээнд ажиллагааны штабыг яаралтай байгуулж, эхний ээлжинд НҮБ-ын 90 ажиглагч офицеруудыг хүлээн авч ажилд нь оруулав. Тун удалгүй Австри болон Фижи Улсын цэргийн багууд ажиллагааны газар оронд хүрэлцэн ирсэн ба 1974 оны 6 дугаар сарын 16-нд гэхэд тэнд үүрэг гүйцэтгэж буй нийт энхийг сахиулагчдын тоо 1,218-д хүрчээ.




Зураг №03. НҮБ-ын хяналтад буй гал зогсоох шугам

НҮБ-ын Гал зогсоох хэлэлцээрийг ажиглах хүчний мандат нь Израйль болон Сирийн гал зогсоосон байдлыг хадгалах, гал зогсоох гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, хоёр улсыг тусгаарласан гал зогсоох зурвасыг хянах зэрэг үүргийг хүлээж байна. Гал зогсоох зурвас нь 75 км урт, 200 метраас 10 км хүртэл өргөнтэй ба уг зурвасыг 3 бүсэд хувааж, өдөр бүр эргүүл, хяналт, ажиглалтын үүрэг гүйцэтгэж байна.

2011 оноос Сири болон Иракийн нутагт "Исламын Улс" террорист бүлэглэл үйл ажиллагаа эрчимтэй явуулж, Сирийн дотоод аюулгүй байдал тогтворгүй болсон. Үүнтэй зэрэгцэн Израйль болон Сирийн харилцаа муудаж, хил болон гал зогсоох зурвасын дагуу жижиг буудалцаан, мөргөлдөөн байнга явагдах болсон ба энэ нь өргөжсөөр их бууны харилцан буудлага, зарим үед пуужин харвах үйл явдал өнөөдрийг болтол өрнөж байгаа юм. Анх 1974 онд НҮБ-ын "UNDOF" ажиллагаа явагдаж эхэлсэн цагаас хойш Голаны өндөрлөгт үүрэг гүйцэтгэж байсан 54 энхийг сахиулагч цэрэг амь насаа алдаад байна[4].

2. www.peacekeeping.un.org UNDOF Fact sheet
3. Israeli-Syrian General Armistice agreement. Signed at Hill 232, Near Mahanayim, on 20 July 1949.
4. www.peacekeeping.un.org UNDOF Total number of fatalities

Өнөөдөр "UNDOF" ажиллагаа нь 940 цэрэг, 30 олон улсын ажилтан, 94 орон нутгийн ажилтантай үүрэг гүйцэтгэж байгаа ба НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс ажиллагааны мандатыг 2019 оны 12 дугаар сар хүртэл сунгажээ.

**Голаны өндөрлөгийн талаар АНУ-ын зүгээс явуулж буй бодлого, түүнд гарч буй өөрчлөлт**

**АНУ нь Сирийн Голаны өндөрлөгийг Израйлийн нутаг дэвсгэр хэмээн үл зөвшөөрсөн гадаад бодлогыг олон жил баримтлаж ирсэн. Гэвч** 2017 онд АНУ-ын Ерөнхийлөгчөөр Д.Трамп **сонгогдон гарч ирснээр уг бодлогод өөрчлөлт орж эхэлжээ.**

АНУ-ын зүгээс Израйль Улсыг дэмжих хоёр том шалтгаан байна гэж үзэж байна. Үүнд: нэгдүгээрт АНУ дахь улс төр, нийгэм, эдийн засгийн нөлөө бүхий еврей иргэдийн "лобби", дэмжлэгтэйгээр Израйль Улсыг арабын ертөнцөд тусгаар тогтнуулах, еврей иргэдийг газар нутагтай болгох, түүнийг тэлэх, тус улсын улс төр, эдийн засгийг хөгжүүлж, бэхжүүлэх асуудал юм. Хоёрдугаарт Ойрх Дорнод, Исламын ертөнцөд өөрийн найдвартай түнш улс, стратегийн түшиц газартай болох "далд бодлого"-той холбоотой ба энэ зорилгоор тус улсын тагнуул, аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт маш их дэмжлэг үзүүлдэг.

Тийм учраас Израйль Улсын Арабын орнуудтай хийсэн 1967,1973 оны дайнд америкчууд төрөл бүрийн зэвсэг, техник, тагнуулын мэдээлэл, хөрөнгө мөнгөөр дэмжлэг үзүүлсэн[5] ба уг тусламж, дэмжлэгийн ачаар өөрөөсөө хэд дахин давуу хүн хүч, хэрэгсэлтэй, зөвлөлтийн хамгийн сүүлийн үеийн зэвсгээр зэвсэглэсэн арабын орнуудыг ялсан түүхтэй.

Мөн түүнчлэн Израйль Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг найдвартай хангах зорилгоор АНУ-аас цөмийн технологи, мэдээлэл, материал, зэвсэг нийлүүлсэн бөгөөд олон улсын "Rand Corporation"-ийн тооцоолж буйгаар өнөөдөр Израйль нь дэлхийд албан ёсоор зарлаагүй боловч ойролцоогоор 65-85 нэгж цөмийн зэвсэгтэй болжээ.[6]

2019 оны 3 дугаар сард АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трамп нь Голаны өндөрлөгийг Израйлийн газар нутаг гэдгийг хүлээн зөвшөөрөх тунхаг бичигт гарын үсэг зурлаа. Ерөнхийлөгч Д.Трамп "АНУ олон жилийн өмнө уг шийдвэрийг гаргах ёстой байсан юм" гэсэн мэдэгдэл хийсэн бол Израйлийн Ерөнхий сайд Б.Нетаньяху уг явдлыг "дипломат ялалт" гэж нэрлээд АНУ-Израйлийн хэлхээ холбоо, улам бүр хүчирхэгжиж байгааг харуулсан явдал боллоо хэмээн дүгнэсэн байдаг[7].

Харин уг алхамыг Сирийн Засгийн газар буруушааж, ерөнхийлөгч Д.Трампыг "Тусгаар улсын газар нутгийн бүрэн бүтэн байдалд бүдүүлгээр халдсан хэрэг" хэмээн нэрлэжээ. ОХУ-ын гадаад хэргийн яам, Ерөнхийлөгч Д.Трампын хийсэн үйлдлийг "хууль бус" гээд, Ойрх Дорнодын нөхцөл байдлыг хурцатгах сөрөг нөлөөтэй гэж шүүмжилжээ. 2019 оны 3 дугаар сарын 28-нд Сирийн саналаар Голаны өндөрлөгийн асуудлаар НҮБ-ын Аюулгүйн зөвлөл шуурхай хуралдсан ба Аюулгүйн зөвлөлийн 14 гишүүн орнууд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 242, 497 дугаар тогтоолын зөрчиж байна хэмээн АНУ болон Израйлийг эрс шүүмжилсэн юм[8]. Эдгээр шүүмжилж буй орнуудын тоонд АНУ-ын хамгийн ойрын холбоотон болох Англи, Франц болон европын улс орнууд багтаж байсан нь анхаарал татаж байв.

5. Dunstan, Simon 2007. The Yom Kippur War: The Arab-Israeli War of 1973.
6. www.nationalinterest.org Don't tell anyone, but Israel has Nuclear weapons, August 10, 2019.
7. Mnb.mn "Голаны өндөрлөг"-ийн талаарх АНУ-ын байр суурийг дэмжсэнгүй. 2019.03.29
8. www.jpost.com 14 out of 15 UNSC member States condemn Israeli sovereignty on Golan. March 28, 2019.

НҮБ-ын зүгээс америкийн үйлдлийг буруушаасан мэдэгдэл гаргасны дараа америкийн талаас хариу арга хэмжээг “далд” байдалтай үзүүлж байгаа. Яагаад гэвэл НҮБ-ын төсвийн 22 хувь буюу 674,2 сая ам.долларыг АНУ дангаараа бүрдүүлдэг бөгөөд уг мөнгөн дүнг бууруулах тухай Ерөнхийлөгч Д.Трампын явуулж буй бодлогын үр дүнд НҮБ-ын төсөв тасалдах, явуулж буй энхийг сахиулах ажиллагаанд хүндрэл гарах магадлал ихсэж байна.

**САНАЛ**

Аюулгүй байдлын чиглэлийн судалгаа, эрдэм шинжилгээний ажил явуулдаг Стратеги судлалын хүрээлэн, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, Аюулгүй байдал судлалын хүрээлэн, Геополитик судлалын хүлээлэнгээр дамжуулан аль нэг том, хүчтэй улс жижиг улсын газар нутгаас тасдан авах, цэргийн хүчээр эзлэж авах, эсвэл тавьсан өр, төлбөртөө газр нутгаас нь суутгаж авахтай холбоотой дараах сэдвүүдээр дэлгэрэнгүй дүн шинжилгээ, судалгааны ажил хийлгэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Ойрх Дорнод болон Исламын ертөнцөд явуулж буй АНУ-ын гадаад бодлого, түүнийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж буй цэргийн үйл ажиллагаа, цаашдын төлөв байдал;
- БНХАУ-ын зүгээс Африк тив, Ази тивд газар нутгийн маргаан, өр зээлтэй холбоотой явуулж буй бодлого, түүний цаашдын чиг хандлагын талаар;
- Сирийн нутаг Голаны өндөрлөгийг өөрийн газар болгох талаар явуулж буй Израйлийн бодлого, стратеги, цэргийн хүчээр эзэлж авсан газрыг бусад улс орнуудаар хэрхэн хүлээн зөвшөөрүүлж байгаа байдал, цаашдын төлөв байдал;
- ОХУ-ын зүгээс Украйны муж болох Крымийг эзлэн авсан цэргийн ажиллагаа, стратегийн ач холбогдол, ОХУ-д хариу үзүүлсэн, хориг арга хэмжээ авсан улс орон, олон улсын байгууллагын үйл ажиллагаа, түүний үр дүн, Олон улсын хууль эрх зүйн орчин, туршлага, сургамж;

Тажикстан Улс Памир дахь өндөрлөг уулын бүсэд 1000 км/кв газрыг БНХАУ-д тавьсан өр, төлбөртөө өгсөн асуудлын улстөр, эдийн засгийн шалтгаан, нутгийн уугуул иргэдийн үзүүлж буй хариу үйлдэл, бусад улс орны байр суурь, цаашдын чиг хандлага зэрэг болно.

Газрын баялаг ихтэй Ойрх Дорнод[9] болон Исламын ертөнцөд зэвсэгт мөргөлдөөн, дайн, тулаан тасралтгүй явагдаж, үүнд их гүрнүүд өөрсдийн ашиг сонирхлоо нэмэгдүүлэх төлөв байдал ажиглагдаж байна. Мөн Африк тивд явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид идэвхтэй оролцдог. Тийм учраас Ойрх Дорнод, Исламын ертөнц, Африк тивд болж буй үйл явц, дайны үйл ажиллагаанд цэрэг, улс төрийн стратегийн үнэлгээ хийх, цэргийн ажиллагааны талаар мэдээлэл цуглуулах, түүнд шинжилгээ хийх, тэнд үүрэг гүйцэтгэж буй монгол цэргүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суугаа Монгол Улсын Элчин сайдын яаманд цэргийн атташе суулгах шаардлагатай байна.

Бидний Ойрх Дорнод болон Украйны зүүн хэсэгт явагдаж буй мөргөлдөөний талаарх мэдээлэл зөвхөн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хязгаарлагдаж байна. Харин үнэн бодит мэдээллийг шуурхай авч байх хамгийн зөв арга зам бол өөрийн төлөөллийг тухайн мөргөлдөөн болж буй газар оронд ажиллуулах явдал юм. Иймд НҮБ-аас Голаны өндөрлөгт явуулж буй энхийг сахиулах ажиллагаа, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас Украйнд явуулж буй хяналтын тусгай ажиллагаанд өөрийн төлөөллийг илгээж оролцуулах, төвийг бодит мэдээллээр тасралтгүй хангах систем бүрдүүлэх гэж үзэж байна.

9. Дэлхийн зэвсгийн худалдааны 40 хувь энэ бүс нутагт ногдддог. Ariel Center for Policy Research paper, number 108.

## ДҮГНЭЛТ

Голаны өндөрлөг нь Сири Улсын нутаг боловч 1967 онд Израйльтай хийсэн дайнаар тэдэнд алдсан ба Сирийн тал өөрийн газар нутгаа буцааж авахаар дайн тулаан, яриа хэлэлцээ хийсэн боловч бүгд амжилтгүй болжээ.

Өнөөдөр уг өндөрлөгийг хяналтандаа байлгах асуудал нь Израйль Улсын үндэсний аюулгүй байдлын амин чухал асуудал болж хувирсан тул Сири Улсад буцааж өгөх ямар ч ашиг, сонирхол байхгүй болж харин ч уг газрыг дэлхийн бусад улс орон, олон улсын байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлэх арга зам сүвэгчлэж байгаа ба үүний эхний үр дүн гарч эхэлжээ.

Бидний хувьд аль нэг хүчирхэг гүрэн хөгжил буурай жижиг улсын газар нутгийг цэргийн хүчээр эзлэх, тасдан авч байгаа жишээ, тохиолдлуудын туршлага, сургамжийг сайтар судлаж, дүн шинжилгээ хийж байх шаардлагатай байна.